



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/60

Алтрага

**Удирдамж батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.10, 23.2.21, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэр дээр Бэлчээрийн ургацыг фото мониторингийн аргаар үнэлэн тогтоох ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээрийн ургацыг фото мониторингийн аргаар үнэлэн тогтоох ажлыг Цаг уурын Баянзүрх өртөө, малчдын бүлэг, нөхөрлөл, бэлчээр ашиглалтын хэсгийн ахлагч нартай хамтран 2024 оны 08 дугаар сарын 01-15-ны дотор зохион байгуулахыг сумын Газрын даамал (Д.Батсайхан), Мал эмнэлэг үржлийн тасаг, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Сумын бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлсэн дүн мэдээг гарган 09 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Газрын асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллагад өргөн мэдүүлэхийг газрын даамал (Д.Батсайхан)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА

ГОДСЭР

Document-Zahiramg

**6729010133**